

**МОНГОЛ УЛС**  
**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ**  
**ТОГТООЛ**

2015-01-14

Дугаар 07

Улаанбаатар хот

“Албан журмын даатгагчдын холбооны санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 12<sup>1.7</sup> дах хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Албан журмын даатгагчдын холбооны санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА

З.НАРАНТУЯА

**АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ  
САНХҮҮГИЙН НЭМЭЛТ ТАЙЛАНГИЙН АГУУЛГА,  
МАЯГТЫГ ТОГТООХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Албан журмын даатгагчдын холбооны санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтооход оршино.

1.2. Албан журмын даатгагчдын холбоо /цаашид Холбоо гэх/ Сангийн сайдын 2005 оны 385 тоот тушаалын 3 дугаар хавсралт “Төрийн бус байгууллагын санхүүгийн тайлангийн маягт”-ын дагуу жил, улирлын санхүүгийн тайланг, энэ журмын дагуу санхүүгийн нэмэлт тайлангийн хамт гаргаж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд Хороонд ирүүлнэ.

**Хоёр. Санхүүгийн нэмэлт тайланг гаргах, ирүүлэх**

2.1. Албан журмын даатгагчдын холбоо нь дараах мэдээллийг энэ журмын 1.2-т заасан хугацаанд, улирал бүр өссөн дүнгээр гаргаж Хороонд ирүүлнэ:

2.1.1. Жолоочийн даатгалын сангийн бүрдүүлэлт зарцуулалтын талаарх мэдээллийг энэ журмын 1 дүгээр хавсралтаар;

2.1.2. Жолоочийн даатгалын сангийн хөрөнгийн байршлын талаарх мэдээллийг энэ журмын 2 дугаар хавсралтаар;

2.1.3. Авлагын талаарх мэдээллийг энэ журмын 3 дугаар хавсралтаар;

2.1.4. Жолоочийн даатгалын сангаас олгосон нөхөн төлбөрийн талаарх мэдээллийг энэ журмын 4 дүгээр хавсралтаар;

2.1.5. Холбооны салбаруудын орлого, нөхөн төлбөрийн талаарх мэдээллийг энэ журмын 5 дугаар хавсралтаар;

2.1.6. Холбооны мэдээллийн санд бүртгэгдсэн жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагч бүрийн байгуулсан жолоочийн даатгалын гэрээ, олгосон нөхөн төлбөр, хураамжийн орлогын талаарх мэдээллийг энэ журмын 6 дугаар хавсралтаар;

**Гурав. Хяналт, хариуцлага**

3.1. Хороо нь энэ журмын биелэлтэд хяналт тавьж ажиллах бөгөөд журмыг зөрчсөн этгээдэд Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**МАЯГТ – ЖД1. ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 20... ОНЫ ... Р  
УЛИРЛЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ**

20... оны ... сарын ... өдөр

(*төгрөгөөр*)

№	Үзүүлэлт	Мөрийн дугаар	Орлогын дүн	Зарцуулалтын дүн
А	Б	В	1	2
<b>1</b>	<b>Эхний үлдэгдэл <math>C_1</math></b>	1		х
<b>2</b>	<b>Орлого мөр 2 = мөр (3:9)<sup>1</sup></b>	2		х
2.1	Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагч бүрээс төвлөрүүлэх хөрөнгө	3		х
2.2	Жолоочийн даатгалын хууль тогтоомжийн зөрчилд ногдуулсан торгуулийн орлого	4		х
2.3	Нөхөн төлбөрийн буцаан төлөлтийн орлого	5		х
2.4	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын 10 хувь	6		х
2.5	Мэдээллийн санг төлбөртэй ашиглуулсны орлого	7		х
2.6	Зээл, тусламж, хандивын орлого	8		х
2.7	Хүүгийн орлого	9		х
<b>3</b>	<b>Зарцуулалт мөр 10 = мөр (11:14)</b>	10	х	
3.1	Нөхөн төлбөр олголт	11	х	
3.2	Жолоочийн даатгалын мэдээллийн сан хөтлөх	12	х	
3.3	Шуурхай алба, сангийн үйл ажиллагааг санхүүжүүлэх	13	х	
3.4	Зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт, сурталчилгааг санхүүжүүлэх	14	х	
<b>4</b>	<b>Эцсийн үлдэгдэл <math>C_2</math> мөр 15 = мөр (12:15)</b>	15	х	

Тайлбар:

ТАЙЛАН ГАРГАСАН: .....

(албан тушаал)

(гарын үсэг)

(овог нэр)

тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН ХУГАЦАА:

20... оны ... сарын ... өдөр

<sup>1</sup> (а:б) гэсэн тэмдэглэгээг цаашид “а”-аас “б” хүртэлх мөрийн нийлбэр гэсэн утгаар ойлгоно. Жишээ нь: (3:9) нь мөр (3+4+5+6+7+8+9) болно. Хавсралт 1-6-д мөн энэ утгаар тэмдэглэгдсэн болно.

**МАЯГТ – ЖД2. ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ХӨРӨНГИЙН БАЙРШИЛ**

20.... оны .... сарын .... өдөр

(төгрөгөөр)

№	Жолоочийн даатгалын сангийн хөрөнгийн байршил	Мөрийн дугаар	Мөнгөн дүн
А	Б	В	1
<b>1</b>	<b>Жолоочийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө мөр 1 = мөр (2+3+9+15+19:22)</b>	1	
1.1	Касс	2	
1.2	Банкны харилцах	3	
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	4	
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	5	
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	6	
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	7	
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	8	
1.3	Банкны хадгаламж	9	
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	10	
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	11	
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	12	
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	13	
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	14	
1.4	Банкны хадгаламжийн сертификат	15	
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	16	
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	17	
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	18	
1.5	Засгийн газрын өрийн бичиг	19	
1.6	Төв банкны үнэт цаас	20	
1.7	Орон нутгийн засаг захиргааны бонд	21	
1.8	Хорооноос зөвшөөрсөн бусад хөрөнгө оруулалт	22	
1.9	Үүнээс: .....	23	
1.10	.....	24	
1.11	.....	25	
<b>2</b>	<b>Жолоочийн даатгалын сангийн хөрөнгөөр бэлдсэн үндсэн хөрөнгө<sup>2</sup> мөр 26 = мөр (27:30)</b>	26	
2.1	Тээврийн хэрэгсэл	27	
2.2	Техник, тоног төхөөрөмж	28	
2.3	Биет бус хөрөнгө	29	
2.4	Бусад хөрөнгө	30	

Тайлбар<sup>3</sup>:

ТАЙЛАН ГАРГАСАН: .....

(албан тушаал)

(гарын үсэг)

(овог нэр)

тамга тэмдэг

<sup>2</sup> Мөр 26-30-д үндсэн хөрөнгийн дүнг элэгдэл хассан цэвэр дүнгээр тайлагнана.

<sup>3</sup> Жолоочийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө байришиж байгаа банкны нэр, дансны дугаар, дансны төрлийг тохирох мөрөнд бичнэ. Мөн мөр нэмж болно. Данс дахь гадаад валютыг тайлант хугацааны эцсийн өдрийн байдлаарх Монгол банкны ханиаар төгрөгт шилжүүлнэ.

ТАЙЛАН ГАРГАСАН ХУГАЦАА:

20... оны ... сарын ... өдөр

“Албан журмын даатгагчдын холбооны санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягт тогтоох журам”-ын 3 дугаар хавсралт

**МАЯГТ – ЖДЗ. АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ 20 ... ОНЫ .... Р УЛИРЛЫН  
АВЛАГЫН ТАЙЛАН**

20... оны ... сарын ... өдөр

(*төгрөгөөр*)

№	Авлагын нэр төрөл	Мөрийн дугаар	Мөнгөний дүн
А	Б	В	1
1	Нийт авлага мөр 1= мөр (2:7)	1	
2	Нөхөн төлбөрийн авлага	2	
3	Даатгалын байгууллагаас авах авлага	3	
4	Төр, төсвийн байгууллагаас авах авлага	4	
5	Урьчилж төлсөн зардал	5	
6	Цалингийн урьдчилгаа	6	
7	Татвар, НДШ-ийн авлага	7	
8	Төлбөртэй үйлчилгээний авлага	8	
9	Бусад авлага	9	

Тайлбар<sup>4</sup>:

ТАЙЛАН ГАРГАСАН: .....

(албан тушаал)

(сарын үсэг)

(овог нэр)

тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН ХУГАЦАА:

20... оны ... сарын ... өдөр

<sup>4</sup> Мөр нэмж авлагын төрлийг нэмж бичиж болно.

**МАЯГТ – ЖД4. ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОСОН НӨХӨН ТӨЛБӨРИЙН МЭДЭЭ**

20... оны .... сарын .... өдөр

(төгрөгөөр)

№	Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох үндэслэл	Нөхөн төлбөр хүссэн өргөдлийн тоо	Нэхэмжилсэн дүн	Өргөдлийн шийдвэрлэлт						Хянагдаж буй материалууд		Буцаан төлөлт
				Даатгалын сангаас олгосон		Даатгалын хохирол үнэлгээний төлбөрт олгосон		Даатгалын сангаас олгохоос татгалзсан				
				тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн	
1	Даатгалгүй этгээд даатгалын тохиолдол гаргасан											
2	Даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээд даатгалын тохиолдол гаргасан											
3	Бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан											
4	Даатгагч дампуурсан											
5	Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл											
	<b>Нийт дүн</b>											

Тайлбар:

ТАЙЛАН ГАРГАСАН: .....

(албан тушаал)

(сарын үсэг)

(овог нэр)

тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН ХУГАЦАА:

20... оны ... сарын ... өдөр

**МАЯГТ – ЖД5. АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ САЛБАРУУДЫН  
20.... ОНЫ .... Р УЛИРЛЫН ОРЛОГО, ЗАРЦУУЛАЛТ**

20.... оны .... сарын .... өдөр  
(төгрөгөөр)

№ А	Салбарын нэр Б	Орлогын дүн			Зарцуулалтын дүн			
		АТБӨЯХАТ – 10%	Торгууль -50%	Бусад орлого	Нөхөн төлбөр олголт	Сангийн үйл ажиллагааны зардал	Сургалт, сурталчилгааны зардал	Бусад зардал
		1	2	3	4	5	6	7
1	Архангай аймаг							
2	Баян-Өлгий аймаг							
3	Баянхонгор аймаг							
4	Булган аймаг							
5	Говь-Алтай аймаг							
6	Дорноговь аймаг							
7	Дундговь аймаг							
8	Завхан аймаг							
9	Өвөрхангай аймаг							
10	Өмнөговь аймаг							
11	Сүхбаатар аймаг							
12	Сэлэнгэ аймаг							
13	Төв аймаг							
14	Увс аймаг							
15	Ховд аймаг							
16	Хөвсгөл аймаг							
17	Хэнтий аймаг							
18	Дархан-Уул аймаг							
19	Орхон аймаг							
20	Налайх							
21	Багахангай							
22	Нийслэл							
	<b>НИЙТ</b>							

Тайлбар<sup>5</sup>:

ТАЙЛАН ГАРГАСАН: .....

.....

(албан тушаал)

(гарын үсэг)

(овог нэр)

ТАЙЛАН ГАРГАСАН ХУГАЦАА:

20... оны ... сарын ... өдөр

<sup>5</sup> Салбарын нэрийг мөр нэмж бичиж болно. Тухайн аймаг, орон нутгийн салбартай холбогдох орлого, хохирлын нөхөн төлбөр, зардлыг бичнэ. Бусад зардлыг нэр зааж, багана нэмж бичиж болно.

**МАЯГТ – ЖД6. ХОЛБООНЫ МЭДЭЭЛЛИЙН САНД БҮРТГЭГДСЭН ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БАЙГАА ДААТГАГЧ БҮРИЙН БАЙГУУЛСАН ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ГЭРЭЭ, ХУРААМЖИЙН ОРЛОГО, ОЛГОСОН НӨХӨН ТӨЛБӨР**

20... оны ... сарын ... өдөр

(төгрөгөөр)

№	Даатгагчийн нэр	Байгуулсан гэрээний тоо	Хураамжийн орлого	Даатгалын тохиолдлын тоо <sup>6</sup>	Олгосон нөхөн төлбөр
А	Б	1	2	3	4
1	“Мөнх даатгал” ХХК				
2	“Номин даатгал” ХХК				
3	“Миг даатгал” ХХК				
4	“Соёмбо даатгал” ХХК				
5	“Ард даатгал” ХХК				
6	“Монгол даатгал” ХХК				
7	“Моннис даатгал” ХХК				
8	“Тэнгэр даатгал” ХХК				
9	“Бодь даатгал” ХХК				
10	“Монре даатгал” ХХК				
11	“Улаанбаатар хотын даатгал” ХХК				
12	“Практикал даатгал” ХХК				
13	“Гэр даатгал” ХХК				
14	“Мандал женерал даатгал” ХХК				
15	“Ган зам даатгал” ХХК				
16	“Хаан даатгал” ХХК				
	<b>Нийт</b>				

Тайлбар:

ТАЙЛАН ГАРГАСАН: .....

(албан тушаал)

(гарын үсэг)

(овог нэр)

тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН ХУГАЦАА:

20... оны ... сарын ... өдөр

<sup>6</sup> Тухайн даатгагчийн нөхөн төлбөр олгосон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын тохиолдлын тоо



## ТАНИЛЦУУЛГА

Албан журмын даатгагчдын холбоо нь Монгол улсад албан журмын даатгалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй даатгагчдыг нэгтгэсэн, хууль, журамд заасан эрх, үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх даатгалын мэдээллийн сан, шуурхай алба, даатгалын сан бүхий ашгийн төлөө бус хуулийн этгээд болно.

Даатгалын тухай хуулийн 12<sup>1.7</sup> дах хэсэгт “Санхүүгийн зохицуулах хороо нь Холбооны үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам зааврыг баталж, уг холбооны үйл ажиллагаанд хяналт тавина”, Жолоочийн даатгалын тухай хуулийн 21.2 дах хэсэгт “Даатгалын тухай хуулийн 12<sup>1</sup> дүгээр зүйлд заасан Албан журмын даатгагчдын холбоо нь Жолоочийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаарх тайланг жил бүр гаргах бөгөөд уг сангийн үйл ажиллагаа, тайланд Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавина” гэж заасан. Мөн Хорооны 2011 оны 337 дугаар тогтоолоор батлагдсан “Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”-д зааснаар Холбоо нь Жолоочийн даатгалын тухай хуульд заасан жолоочийн даатгалын сан, мэдээллийн сан, зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт сурталчилгааг санхүүжүүлэхэд зарцуулах хөрөнгийн төсвийг Хороогоор хянуулж, сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын улирлын тайланг Хороонд ирүүлэх, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг Хороонд тайлагнах үүрэгтэй.

Холбоо нь төрийн бус байгууллага тул байгуулагдсан цагаасаа хойш Сангийн сайдын 2005 оны 385 дугаар тушаалаар баталсан “Төрийн бус байгууллагад мөрдөх дансны нэгдсэн жагсаалт”, “Төрийн бус байгууллагын Санхүүгийн тайлан, түүний тодруулгыг бэлтгэх заавар”, “Төрийн бус байгууллагын санхүүгийн тайлангийн маягт”-ын дагуу жил, улирлын санхүүгийн тайлан гаргаж Хороонд болон холбогдох байгууллагуудад хүргүүлдэг.

Холбооны хөрөнгийн эх үүсвэрийг Даатгалын тухай хуулийн 12<sup>1.6</sup> дахь хэсэгт, жолоочийн даатгалын сангийн эх үүсвэр, бүрдүүлэлт, зарцуулалтыг Жолоочийн даатгалын тухай хуулийн 22, 23 дугаар зүйлд заасан байдаг бөгөөд Төрийн бус байгууллагын үр дүнгийн тайлангаар улирал бүр эдгээр орлого, зарцуулалтыг хуульд заасны дагуу ангилан тайлагнах боломжгүй, тэдгээрийг тайлагнах батлагдсан маягт байдаггүй нь Хорооноос холбооны үйл ажиллагаанд хуулийн дагуу хяналт тавьж ажиллахад хүндрэлтэй байдаг.

Иймд Холбооны болон жолоочийн даатгалын сангийн орлого бүрдэлт, тэдгээрийн зарцуулалтын байршил, хохирогчдод олгосон нөхөн төлбөр, жолоочийн даатгалын мэдээллийн санд бүртгэгдсэн жолоочийн даатгалын гэрээ, нөхөн төлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хүлээн авах, Холбоо, жолоочийн даатгалын сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах үүднээс Даатгалын тухай хуулийн 12<sup>1.7</sup> дахь хэсэгт заасны дагуу “Албан журмын даатгагчдын холбооны санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягыг тогтоох журам”-ын төсөлийг боловсруулан, Албан журмын даатгагчдын холбоо, Хорооны Тамгын газрын Санхүүгийн тайлагнал, судалгааны хэлтсийн саналыг авч, журмын төсөлд тусган, Хорооны хуралдаанд оруулж байна.

Хянасан: ДГ-ын дарга

ДГ-ын АЖБАДХ-ийн дарга

Боловсруулсан: ДГ-ын АЖБАДХ-ийн хянан шалгагч

С.Ганболд

П.Ууганбаяр

Ц.Долгорсүрэн



**ХОРООНЫ ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХЭЭР  
БЭЛТГЭСЭН ТӨСЛИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС**

**Шийдвэрийн төслийн нэр:** “Албан журмын даатгагчдын холбооны санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам”-ыг батлах тухай

1. Зөвшөөрсөн: \_\_\_\_\_ /Дарга З.Нарантуяа/  
\_\_\_\_\_ Огноо
2. Танилцсан: \_\_\_\_\_ /Хорооны гишүүн Х.Бум-Эрдэнэ/  
\_\_\_\_\_ Огноо  
\_\_\_\_\_ /Хорооны гишүүн Э.Батболд/  
\_\_\_\_\_ Огноо
3. Хянасан: \_\_\_\_\_ /Ажлын албаны дарга Ц.Энхбаяр/  
\_\_\_\_\_ Огноо  
\_\_\_\_\_ /ДГ-ын дарга С.Ганболд/  
\_\_\_\_\_ Огноо  
\_\_\_\_\_ /Эрх зүйн хэлтсийн дарга О.Батбилэг/  
\_\_\_\_\_ Огноо  
\_\_\_\_\_ /ДГ-ын АЖБАДХ-ийн дарга П.Ууганбаяр/  
\_\_\_\_\_ Огноо
4. Төсөл боловсруулсан ажилтан:  
\_\_\_\_\_ /ДГ-ын АЖБАДХ-ийн хянан шалгагч  
Ц. Долгорсүрэн/  
\_\_\_\_\_ Огноо
5. Хуралдаанд гаднаас оролцох төлөөлөгч:  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_ /овог, нэр/ \_\_\_\_\_ /байгууллага/ \_\_\_\_\_ /албан тушаал/
6. Төслийг хүлээн авч, олшруулахыг зөвшөөрсөн:  
\_\_\_\_\_ /Тамгын газрын дарга Н.Батгэрэл/  
\_\_\_\_\_ Огноо

7. Санал

---